



ГАДААДЫН ИРГЭН, ХАРЪЯАТЫН  
ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2018 оны 12 сарын 20 өдөр

Дугаар А/432

Улаанбаатар хот

Зарим албан хаагчдад мөнгөн урамшуулал  
олгох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын 8 дугаар зүйлийн 8.3.5, 8.3.7, Төрийн албаны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2, Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1, Засгийн газрын 1995 оны 96 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан "Төрийн алба хаагчид шагнал, урамшил олгох журам"-ын 2.в, 5, байгууллагын даргын 2017 оны А/441 дүгээр тушаалаар баталсан "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 9.3-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.2018 оны жилийн ажлын үр дүнгээр "А" үнэлгээ авсан албан хаагчдад үндсэн цалингийн 80 хувь, "В" үнэлгээ авсан албан хаагчдад үндсэн цалингийн 70 хувьтай тэнцэх мөнгөн урамшууллыг хавсралт ёсоор олгосугай.

2.Мөнгөн урамшуулалд шаардагдах 10 280.187 /арван сая хоёр зуун наян мянга нэг зуун наян долоо/-н төгрөгийг зохих зардлаас тооцож олгохыг Санхүүгийн хэлтэс /Б.Даваажав/, Буянт-Ухаа дахь газар /Г.Төгөлдөр/, Дорноговь аймаг дахь газар /П.Тулга/, Зүүн бүс дэх газар /Б.Тамир/, Өмнөд бүс дэх газар /Л.Дамдинсүрэн/-т тус тус зөвшөөрсүгэй.

3.Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар /Д.Давааням/-т даалгасугай.

ДАРГА

Д.МӨРӨН

000001773